

**“БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ШАГНАЛЫН ТӨРӨЛ, ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ”-ЫН ТӨСӨЛ**

Зорилго: Дүүргийн удирдлагаас нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилт, гаргасан шийдвэрийг биелүүлэхэд идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан төр захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, албан хаагч, иргэдийг идэвхжүүлэн урамшуулах, үйл ажиллагааг нь үнэлж дүгнэхэд чиглэгдэнэ.

Нэг. Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал,
Засаг даргын шагналын төрөл

1.1. ИТХ, Засаг даргын хамтарсан шагнал

- Хүндэт иргэн
- Хүндэт өргөмжлөл

Хүндэт иргэн /хүндэт дэвтэрт бичнэ/

Дүүргийн хөгжил цэцэглэлтийн төлөө онцгой гавьяа байгуулсан, дүүргийн иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаа хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн, тухайн салбартаа шинэ нээлт бүтээл гаргасан болон олон улсын чанартай уралдаан тэмцээнд удаа дараа амжилт гаргаж, дүүргийн нэр төрийг өндөрт өргөсөн, дүүрэгт 10-аасдоошгүй жил үр бүтээлтэй, идэвх зүтгэлтэй ажилласан иргэнийг шагнаж урамшуулна.

“Хүндэт иргэн”-д 500.000 /таван зуун мянга/ төгрөгийн дагалдах мөнгөн шагнал олгож, дүүргийн түүхэнд мөнхлөх зорилгоор “Хүндэт дэвтэр”-т нэрийг тухайн иргэний товч түүх, байгуулсан гавьяа, шагнал олгосон шийдвэрийн хамтбичнэ.

Хүндэт өргөмжлөл

Тухайн онд төрийн захиргааны байгууллагаас зохиосон цаг үеийн холбогдолтой арга хэмжээнд амжилт гаргасан байгууллага, иргэнд олгож урамшуулна.

“Хүндэт өргөмжлөл”-өөр шагнагдсан байгууллагад 200.000 /хоёр зуун мянга/, иргэнд 100.000 /нэг зуун мянга/ төгрөгийн дагалдах мөнгөн шагнал олгоно.

Хамтарсан шагналыг ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-аас ирүүлсэн тодорхойлолтыг үндэслэн ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хамтарсан хурлаар шийдвэрлэж, дүүргийн “Иргэдийн өдөрлөг”-ийн үеэр гардуулна.

1.2. ИТХ-ын шагнал

- Хүндэт өргөмжлөл
- Хүндэт үнэмлэх

Монгол Улсын хууль, Засгийн газрын болон нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг амьдралд бүтээлчээр хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцсон, гэмт хэрэг, зөрчил, нийгмийн дэг журмыг хангах, нийтийн эзэмшлийн зам талбай, хашаа байшин, гудамж орчноо тохижуулахад иргэний үүргээ нэр төртэй үлгэр жишээ биелүүлж, хамт олноо

манлайлан үр бүтээлтэй ажилласан тэргүүний байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, албан хаагчдыг шагнаж урамшуулна.

ИТХ-ын шагналыг ИТХ-ын төлөөлөгч, төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллага, Иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн тодорхойлолтыг үндэслэн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэнэ. Хүндэт өргөмжлөлийг 50.000 /тавин мянга/ ,Хүндэт үнэмлэхийг 30.000 /гучин мянга/ төгрөг дагалдана.

1.3. Засаг даргын шагнал

- Дүүргийн хүндэт тэмдэг
- Баярын бичиг

Хүндэт тэмдэг

Дүүргийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх, үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлж, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлсэн, хот дүүргийн хөгжил бүтээн байгуулалтанд хөрөнгө санхүүгийн бодитой туслалцаа үзүүлж үр дүнд хүргэсэн, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан тэргүүний хүмүүсийг шагнаж урамшуулна. Шагналыг 50.000 /тавин мянга/ төгрөг дагалдана.

Баярын бичиг

Дүүргийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан, төр захиргааны бодлого шимидвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх ажилд хамт олноо хошуучлан идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан тэргүүний байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, иргэд, албан хаагчдыг шагнаж урамшуулна. Шагналыг 30.000/гучин мянга/ төгрөг дагалдана.

Засаг даргын шагналыг ИТХ-ын ажлын алба, аж ахуйн нэгж, албан байгууллага болон олон нийтийн байгууллага, Иргэдийн нийтийн хурлаас ирүүлсэн тодорхойлолтыг үндэслэн Засаг даргын зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

1.4. Багахангай дүүргийн ИТХ, Засаг даргын шагналаар шагнагдах хүмүүс нь дараах болзлыг хангасан байна

- Тухайн байгууллагад 2-оос доошгүй жил тогтвор сууршилтай, үр бүтээлтэй ажилласан байх
- Гэмт хэрэг зөрчилд холбогдоогүй, ёс суртахууны доголдолгүй байх
- Иргэний үүргийн биелэлтийг хангасан байх

Нийслэлийн Багахангай дүүргийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны....сарын
....-ны өдрийн хуралдааны.... дугаар
тогтоолынхоёрдугаар хавсралт

**“НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ОНЫ
ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА БАЙГУУЛЛАГА, АЖИЛТАН
ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ”-ЫН ТӨСӨЛ**

Нэг. Нийтлэг үндэслэл

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагч, иргэдийн тухайн жилийн хөдөлмөр бүтээл, амжилтыг урамшуулан дэмжиж, олон түмэнд сурталчлах, алдаршуулах, шалгаруулалтыг тогтсон нэг үзүүлэлт системд хамруулахад энэхүү журмын зорилго оршино.

**Хоёр. Дүүргийн оны хөдөлмөрийн аварга байгууллага,
ажилтан шалгаруулах шалгуур үзүүлэлт**

Дүүргийн Хөдөлмөрийн аваргаар шалгарсан байгууллага, иргэдэд олгох шагнал нь дүүргийн ИТХ-ын дарга, Засаг даргын хамтарсан шагнал байх ба дүүргийн тухайн оны хөдөлмөрийн аварга хамт олон, ажилтныг дараах шалгуур үзүүлэлтээр шалгаруулж, үнэлж дүгнэнэ. Үүнд:

1. Хөдөлмөрийн аварга байгууллага
2. Төрийн байгууллагын аварга ажилтан
3. Нийгмийн салбарын аварга ажилтан
4. Худалдаа, үйлчилгээний аварга ажилтан
5. Дэд бүтцийн аварга ажилтан
6. Төмөр замын аварга ажилтан
7. Сайн малчин
8. Шилдэг залуу
9. Шилдэг оюутан
10. Шилдэг сурагч
11. Шилдэг менежер

Гурав. Хөдөлмөрийн аварга байгууллага, ажилтан шалгаруулах салбар, төрөл

3.1. Хөдөлмөрийн аварга байгууллага

Тухайн жилийн Нийслэл, дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, нийслэл, дүүргийн эдийн засаг, нийгмийн зорилтыг бүрэн биелүүлсэн, журамд заасан болзол шалгуурыг хангасан аж ахуйн нэгж, байгууллага

3.2. Төрийн байгууллагын аварга ажилтан

ЗДТГ, ИТХ, Дотоод Аудитын алба, Өмч, газрын харилцааны алба, Худалдан авах ажиллагааны алба, Улсын Бүртгэл, статистикийн хэлтэс, Татварын хэлтэс, Онцгой байдлын

хэлтэс, Цагдаагийн тасаг, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөрийн хэлтсийн болон Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн төрийн захиргааны албан хаагчид

3.3. Нийгмийн салбарын аварга ажилтан

Сургууль, цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын ордон, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв, Биеийн тамир спортын хороо, Ахмадын хороо, Хөдөлмөрийн хэлтсийн болон Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн төрийн үйлчилгээний албан хаагчид

3.4. Худалдаа, үйлчилгээний аварга ажилтан

Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, банк, нийтийн тээвэр, шуудан холбоо, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв, хот тохижилтын чиглэлээр үйлчилгээ явуулж байгаа байгууллагууд

3.5. Дэд бүтцийн салбарын аварга ажилтан

Дулаан, эрчим хүч, барилга, орон сууц, усан хангамж, Сууц өмчлөгчдийн холбоод

3.6. Төмөр замын салбарын аварга ажилтан

Төмөр Замын салбарт ажиллагсад

3.7. Сайн малчин

Дүүргийн бүх малчид /аж ахуйн нэгж, байгууллагын малчид орно/

3.8. Шилдэг залуу

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид ажилладаг

3.9. Шилдэг оюутан

Сурлага, хөдөлмөр, урлаг спортод онцгой амжилт гаргаж, дүүрэг орон нутгийн нэрийг улс, нийслэлийн хэмжээнд болон олон улсын хэмжээнд өндөрт өргөж буй, дүүргийн харьяат их дээд сургуулийн оюутан 25 хүртэлх насны өдрийн ангийн суралцагч

3.10. Шилдэг сурагч

Дүүргийн Ерөнхий боловсролын сургуульд суралцдаг, сурлага, урлаг, спорт, соёл хүмүүжлээр тэргүүлсэн сурагч

3.11. Шилдэг менежер

Тухайн онд шилдэг байгууллагаар шалгарсан байгууллагын дарга нь “Шилдэг менежер” байна.

Дөрөв. Дүүргийн “Хөдөлмөрийн аварга”-аар шалгаруулах иргэнийг дараах болзол шалгуураар үнэлж дүгнэнэ

1. Тухайн дүүрэг, байгууллагад 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан, дүүргийн үндсэн иргэн байх
2. Хөдөлмөрийн амжилт гаргасан тодорхой үзүүлэлтүүд /байгууллагын тодорхойлолт, хамт олны хурлын тэмдэглэл байна/
3. Хорооны Засаг даргын тодорхойлолт, иргэний үүргийн биелэлтийн талаар холбогдох байгууллагын тодорхойлолт/гэрэл, цахилгаан, орон сууц, усны төлбөр/
4. Гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн талаарх Цагдаагийн тодорхойлолт
5. Хугацаа хэтэрсэн татварын өргүй байх

6. “Шилдэг сурагч”-д нэр дэвшүүлэхдээ4-өөс дээш сурагчийн тодорхойлолт, холбогдох материалыг ирүүлнэ.

Тав. Дүүргийн “Хөдөлмөрийн аварга байгууллага”-аар шалгаруулах аж ахуйн нэгж, байгууллагыгдараах үзүүлэлт, болзол шалгуураар үнэлж дүгнэнэ

Үүнд:

1. Тухайн жилд хийсэн ажлын үзүүлэлт,үндсэн үүрэг,улс эх орон, дүүрэгт оруулсан хувь нэмэр
2. Санхүү эдийн засгийн үйл ажиллагаа, төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал
3. Дүүргийн хэмжээнд нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлсэн байдал,шинэлэг, бүтээлч ажил, үр дүн
4. Ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал
5. Дүүрэг, орон нутгийн зүгээс зохион байгуулсан ажилд хамт олноо оролцуулсан байдал
6. Хамт олны сахилга, хариуцлага, дэг журам, гэмт хэрэг, хэв журмын зөрчил гаргасан ажилтан байгаа эсэх
7. Салбарын хэмжээнд ажил мэргэжлийн уралдаанд оролцсон байдал, гаргасан амжилт
8. Хууль, тогтоомжийн хэрэгжилт
9. Архив, албан хэрэг хөтлөлт, дотоод ажлын эмх цэгц
- 10.Санхүүгийн болон аудитын шалгалтаар зөрчилгүй дүгнэгдсэн байхзэрэг болно.

Шалгарсан байгууллагыг өргөмжлөл, 300.000/гурван зуун мянга/ төгрөгийн шагналаар шагнаж урамшуулна.

Зургаа. Шагнах журам

Дүүргийн тухайн жилийн хөдөлмөрийн аварга ажилтан, шилдэг залуу, шилдэг оюутанд 100.000 /нэг зуун мянга/төгрөгийн, шилдэг сурагчид 50.000 /тавин мянга/төгрөгийн дагалдах мөнгөн шагналыголгоно. Дагалдах мөнгөн шагналыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргана.

Долоо. Материал хүлээн авах, шалгаруулах

6.1. Дүүргийн хөдөлмөрийн аваргаар тодорхойлсон байгууллага, иргэдийн материалыг тухайн жилийн 12 дугаар сарын 10-ны дотор хүлээн авч 15-25-ны өдрийн дотор дүгнэнэ.

6.2.Ажил дүгнэх ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын захирамжаарбайгуулах ба ажлын хэсэг журмын дагуу үнэлж дүгнэн, хамтарсан хуралдаанд уламжилна.

Найм. Бусад зүйл

7.1.Дүүргийн аварга байгууллага,ажилтнаар шалгарсан хамт олон,иргэндгардуулах өргөмжлөл, үнэмлэх, туузанд дүүргийн сүлд, тэмдгийг хэрэглэнэ.

7.2. Энэ журмыг2016 оны 06дугаар сарын01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.